



# СОЁМБО МЭДЭЭ


МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№209 /418/ 2022.11.18

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ХЯНАН ШАЛГАГЧААР АХЛУУЛСАН АЖЛЫГ ХЭСЭГ ХУРАЛДЛАА



2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр цахим орчинд "Шинэ Соёмбо" гэх компанийн хамгаалалтын ажилчид Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчдын дүрэмт хувцас, хэрэглэлийг өмссөн талаар мэдээлэл түгсэн билээ. Уг асуудалтай холбогдуулан өнөөдөр Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг

хуралдаа.

Ажлын хэсэг 2022 оны 11 дүгээр сарын 22-ноос 12 дугаар сарын 2-ны өдрүүдэд Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй харуул хамгаалалтын албан байгууллагууд цэргийн хувцас, цол, ялгах тэмдгийг хэрэглэж байгаа эсэх, албан ёсны эрхгүйгээр цэргийн дүрэмт хувцас

үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж, зарж борлуулж буй захуудад шалгалт хийж холбогдох зөрчил, дутагдлыг илрүүлэн ажиллах бөгөөд үр дүнг ирэх сарын 6-ны өдөр Батлан хамгаалахын сайдад танилцуулах шийдвэрийг гаргалаа.

Ө.НАСАНТОГТОХ



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-2	-16

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	21

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.427	3.435
EUR	3.565	3.580
CNY	475	480
RUB	53.90	54.10
JPY	24.30	24.60
KRW	2.58	2.61

### ЗУРХАЙ

2022.11.18 /БААСАН ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 25

**НАМРЫН АДАГ ЦАГААН  
НОХОЙ САР  
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ  
ХӨХӨГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Нүд бүрэлзэн улцайна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.02-17.12

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

## ДЭВШҮҮЛЭН ТОМИЛОВ



### Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн тушаалаар Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч-штабын дарга дэд хурандаа Д.Энх-Амгаланг дэвшүүлэн Агаарын цэргийн командлалын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн ажиллагааны удирдлагын ахлах офицер, тагнуулын даргаар, Агаарын цэргийн командлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн радио техникийн инженер дэд хурандаа Т.Нямхүүг тус ангид захирагчийн нэгдүгээр орлогч-штабын даргаар дэвшүүлэн томиллоо.

Ажил хүлээлцүүлэх комиссын бүрэлдэхүүн энэ сарын 14-16-ны өдрүүдэд ажилласан бөгөөд энэ үеэр Агаарын цэргийн штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат шинээр дэвшин томилогдсон албан тушаалтнуудад амжилт хүсэж, Зэвсэгт хүчний хөгжил шинэчлэлийн төлөө хичээж ажиллахыг үүрэг болгосон юм.




## ЦЭЦЭН БУУГАА МӨРЛӨСӨН ШИНЭХЭН ДАЙЧДААС ОНЦ БУУДАГЧИД ТОДОРЛОО

Энэ сарын 16-ны өдөр Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хурандаа О.Сэрдарийн нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 015 дугаар ангид 2022 оны II ээлжээр татагдан ирсэн дайчид цэрэг хүний бахархал болсон тангаргийн буудлага амжилттай хийв.

Энэ үеэр 14 байлдагч онц буудагчийн болзлыг хангалаа.

Ахлах дэслэгч  
Д.ДАВААЖАРГАЛ



## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 641,979,979

Эдгэрсэн

Нийт: 621,415,384

Нас барсан

Нийт: 6,621,891

Цахим шууданд

## БАЙЛДАГЧДЫН ТӨРСӨН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭВ



**Зэвсэгт хүчний 167 дугаар анги** зөвлөл, Мотобуудлагын батальоны хамт олон хамтран Ангийн эмэгтэйчүүдийн сар бүр тухайн сард төрсөн

хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэдэг билээ. Уг үйл ажиллагааны хүрээнд энэ сарын 18-ны өдөр 10, 11 дүгээр сард төрсөн нийт 25 хугацаат цэргийн алба хаагчийн төрсөн өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд төрсөн өдрөө тэмдэглэж буй хугацаат цэргийн алба хаагчдад гарын бэлэг гардуулж, нийт дайчдын дунд хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион явууллаа.

Дэслэгч **Б.БАТЗАЯА**

## АЯЛАН ТОГЛОЛТ ТАНКИЙН ТУСГАЙ ХОРООНД...



**Зэвсэгт хүчний 256 дугаар анги** 2022 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан дайчдад Монгол Улсын

соёлын тэргүүний ажилтан, "Номин талст" хамтлагийн гишүүн дуучин Т.Дэлгэрмөрөн, дуучин О.Баянмөнх нарын "Найрсаг байгаасай" аялан тоглолтыг ангийн соёл спортын төвд үзүүлж сонирхууллаа.

Тус тоглолтын үеэр дуучин Т.Дэлгэрмөрөн, О.Баянмөнх нар хугацаат цэргийн алба хаагчидтай Төрийн алтан "Соёмбо"-ны талаар яриа хийсэн бөгөөд төрийнхөө соёмбыг тэргүүнээ залж иргэний-цэргийн үүргээ биелүүлж байгаа цэрэг дайчдаараа бахархаж байгаа илэрхийлсэн юм.

Энэхүү арга хэмжээ нь хугацаат цэргийн албанд ирээд удаагүй байгаа дайчдын сэтгэл зүйг өргөсөн, алба хаах хүсэл тэмүүллийг нь бадраасан, цэргийн албаар бахархах сэтгэлийг нь өдөөсөн дурсамж дүүрэн арга хэмжээ боллоо.

Хошууч **Л.АМАРБАЯСГАЛАН**

## АХЛАГЧ НАРЫН СУРГАЛТЫГ ШИНЭЛЭГ БАЙДЛААР...



**Зэвсэгт хүчний 325 дугаар анги**

2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу энэ сарын 17-ны өдөр Завхан аймгийн "Орон нутгийн музей"-тэй хамтран ангийн ахлагч нарын цугларалтыг шинэлэг байдлаар зохион байгууллаа.

Цугларалтаар 17 танхимын 3000 гаруй үзмэр, эд өлгийн зүйлс бүхий 98 жилийн түүхтэй музей болон Завхан аймгаас төрөн гарсан хоёр Ерөнхийлөгч, 13 хутагт, 25 генералын гавьяа, түүх, эдэлж хэрэглэж байсан эд өлгийн зүйлс бүхий "Алдартнуудын музей"-г ахлагчийн бүрэлдэхүүн үзэж сонирхлоо.

Мөн энэ үеэр бие бүрэлдэхүүн Монголын оюун ухааны музейг үүсгэн байгуулагч, зохион бүтээгч З.Түмэн-Өлзийн бүтээсэн оньсон тоглоомоор оюун ухаанаа сорьсноос гадна ажиллаж амьдарч буй орон нутгийнхаа түүх соёлын талаарх мэдлэгээ ахиулсан, иргэн цэргийн харилцааг бэхжүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

**Б.ХАТАНБААТАР**

## ХЭЭРИЙН НӨХЦӨЛД ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



**Зэвсэгт хүчний 337 дугаар анги**

2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу үндсэн болон тайван цагт хүлээсэн үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийг тодотгох, тэдгээрийн бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшин, цэргийн алба хаагчдын мэдлэг, дадлага, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор энэ сарын 16-ны өдөр ангийн бие бүрэлдэхүүнийг "Цугларах" дохиогоор ажиллууллаа.

Мөн энэ үеэр бие бүрэлдэхүүн 30 км-ийн явган маршийг үйлдэж цэргийн байр зүйн бэлтгэл, ерөнхий тактик, амьд гарах арга ухаан, эмнэлгийн бэлтгэл гэсэн таван цэгт үүрэг гүйцэтгэсэн юм.

Эмнэлгийн бэлтгэл хичээлийн цэгт шархадсан цэргийн алба хаагчийг галын сектороос хэрхэн татан гаргах, эмнэлгийн анхан шатны тусламжийг хэрхэн үзүүлэх, ил шарх, цус алдалт, хугаралт, ухаан алдсан үед ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх сургалтыг явуулж, дадлага хийлээ.

**Ахмад Ж.САЙНЗАЯА**

## "АЛДАР"-ЫН ТАМИРЧИН ШАТРЫН БОДЛОГО БОДОЛТЫН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД



Энэ сарын 13-19-ний өдрүүдэд Арабын нэгдсэн Эмират Улсын Фужайрах хотод зохион байгуулагдаж буй Шатрын Бодлого Бодолтын Дэлхийн аварга шалгаруулах 45 дахь удаагийн тэмцээнд "Алдар" спорт хорооны тамирчин шатрын их мастер С.Билгүүн амжилттай оролцлоо.

Дэлхийн 20 гаруй орноос шилдэг 82 бодогч оролцсон тус тэмцээнд шатрын их мастер С.Билгүүн боломжит 90 оноос 77,75 оноо цуглуулж, шагналт IV байрт шалгарч бодлого бодолтын Их Мастер цолны анхныхаа нормыг биелүүллээ.

Дэлхийд шатар тоглолтын болон бодлого бодолтын төрлөөр давхар их мастер цолтой 10 хүрэхгүй тамирчин байдгийг зохион байгуулагчид хэлж онцгой амжилт ойрхон байгааг манай тамирчинд санууллаа. Тамирчин маань III үе хүртэл тэмцээнийг тэргүүлсэн хэдий ч HELPMATE буюу Хамжаа мэднэ үед чухал оноонуудыг алдаж медалиас атгаад алдсан ч цаашид ямар нөөц бололцоо байгааг харуулсан сайхан тэмцээн боллоо.


## СУРГАЛТ

### МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №24

#### УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА

Өмнө нь, бид НА дэвсгэр үсгийн тухай үзсэн билээ. Одоо тэрхүү НА үсэг болон үндсэн 7 эгшиг оролцсон, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь одоогийнхтой бараг таардаг хялбар жишээ үсгийг унших, бичих дасгал дадлага хийцгээе.

Дармал, бичмэл тигээр:



## Хүүе, Та дуулсан уу?

66

2022 оны 11-р сарын 01-ний өдрөөс эхлэн Утасны төлбөр, Орон сууцны төлбөр, Албан хаагчдаас авах авлага зэрэг цалин хөлснөөс суутган авч буй бусад суутгалуудыг суутгахгүй болсон шүү.